



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 137

Улаанбаатар хот

Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн томилох тухай


Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, тус газрын даргын 2013 оны 116 дугаар тушаалаар батлагдсан “Мэдээллийн технологийн үндэсний паркийн дүрэм”-ийн 7.1, 7.2, 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Мэдээллийн технологийн үндэсний паркийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Тус паркийн Удирдах зөвлөлийн даргад Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Бүх нийтийн үйлчилгээний ажлын албаны дарга Б.Буян-Өлзийг дэвшүүлэн хэлэлцүүлэхийг Мэдээллийн технологийн үндэсний паркийн Удирдах зөвлөлд санал болгосугай.

Гурав. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын “Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай” 2012 оны 34 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ЖАДАМБАА

111823

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны
газрын даргын 2014 оны 2 сарын 22 өдрийн
ХТД дугаар тушаалын хавсралт



**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРКЫН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- | | |
|---------------|--|
| Б.Буян-Өлзий | Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Бүх нийтийн үйлчилгээний ажлын албаны дарга |
| Б.Алтансүх | Мөн газрын Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга |
| Б.Мөнхтулга | Мөн газрын Хяналт, шинжилгээний газрын дарга |
| Г.Чинзориг | Мөн газрын Мэдээллийн технологи, инновацийн хэлтсийн дарга |
| Ч.Лодойравсал | МУИС-ийн Мэдээллийн технологийн сургуулийн захирал |
| Б.Нэмэхбаяр | Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн |
| В.Баярсайхан | Синглтон ХХК-ний гүйцэтгэх захирал |